



Согоогийн 45 га хадлан хаших төсөл

Баян-Өлгий
аймгийн Улаанхус
сумын СБАХ,
Улаанхарган БАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 5- 10 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 23,705,000 ТӨГ:

Төсөл хэрэгжсэн газар

Баян-Өлгий аймаг, Улаанхус сум, Согоогийн хадлан

Төслийн зорилго

Бэлчээр нутгаа сэлгээн, өнжөөхийн тул зуслангийн нүүдэл хийдэг Улаанхаргана БАХ-ын 10 малчин өрхийн өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх, бүлгийн малчдын өвлийн нөөц бэлчээр бий болгох, амьжиргааг сайжруулах, цаашид БАХ-ын малчдын амжиргааны эх үүсвэр болсон бэлчээр нутгаа хамгаалахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төслийн зорилтууд

- 1.10 малчин өрх нийлж 5 жилийн өмөнө шийдвэр гаргав.
- 2.Хадлангийн талбайн бүтээмжийг дээшлүүлэх.
- 3.Өвлийн нөөц бэлчээртэй болох.
- 4.Тэжээлийн найдвартай нөөцтэй болох.
5. Бэлчээр нутгаа хамтын хүчээр хамгаалах.

Үйл ажиллагаа

- 1.10 малчин өрх нийлж 5 жилийн өмөнө шийдвэр гаргав.
- 2.Хадлангийн талбайн усалгааны сувагуудыг сэргээх.
- 3.Хашаалах талбайн чулууг түүж хашаалж эхэлсэн.
- 4.Аймгийн төвөөс хашаалах материал жил болгон татах.
- 5.Үерийн хамгаалалтын суваг татав /трактор хөлсөлж/.
6. Торон хашааг тойруулан хамгаалах суваг татав.
7. Төмөр тор авах хөрөнгө мөнгө хүрээгүй 700м газрыг төслийн санхүүжилтээр хашаалав

Төслийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	2,000,000
ОНХС	
СБАХ	
Малчид	21,705,000
Нийт	23,705,000

Төслийн санхүүжилтийн буцалтгүй



Төмөр тор дутуу татсан 700м хашааны өмөнөх байдал.



Төслийн хөрөнгөөр сүлжмэл бэлэн тор авч өгч татуулсаны дараах байдал

Сургамж

барьж дуусгаж чадаагүй хашааг
малчдын байгууллагын төслийн
Бүлгийн малчдын зорилго, зорилтод дэмжлэгтэйгээр дуусгасандаа малчид
хүрэхээр, хамтын хүч хөрөнгөөр 5 жил талархаж байна.

Хөрөнгө оруулалтын зарцуулалт.

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Сүлжмэл төмөр тор	м	715	2800	2,000,000
2					
	Нийт				2,000,000

Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна. Орон нутгийн ханш машин өвс-500,000 ₮

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
	Машин өвс	ш	6	500,000	3,000,000
	Нийт				3,000,000

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулна. Үүнд:

- ↑ 2020 оны намар 10 айл 6 машин буюу 14 тн өвс авч тэжээлийн нөөц бүрдүүлж байгаа, хашааг хадлан авсаны дараа бүрэн татсан, энэ өвөл 45 га хашаалсан талбайг өвлийн нөөц бэлчээрийн зориулалтаар хамгаалж, цаг агаар хүйтэрч хүндэрсэн үед ашиглахаар нөөцөлж байгаа байна.
- ↑ Борлуулалт нэмэгдсэн байдал: Энэ жил намар хадлангийн улирал өнгөрсөний дараа төсөл хэрэгжиж, хашаалсан тул борлуулалтанд нэмэгдэл гараагүй
- ↑ шинээр бий болсон хөрөнгө: Хашсан хадлангийн талбайтай, хамгаалагдсан бэлчээртэй болсон нь их давуу тал болсон.
- ↑ цэвэр ашиг, хадлангийн хашаалсан өртөг, зардлаа дараа жилээс бүрэн төлж цаашид орлого орж ашигтай ажлахаар байна.
- ↑ Нийгмийн ашиг тус: 10 өрхийн хашаалсан хадлангийн талбайтай болохоос гадна уналгын морь, турж эссэн малаа оруулах хамгаалагдсан 45 га нөөц бэлчээртэй болж, өрхийн орлого

хэмнэгдэж, малчдын тэжээлийн найдвартай нөөц би болох боломж олгосон. Цаашид сүүний үхэр, гүүний ферим хөгжүүлж орлого олох боломжтой болсон шинээр нэмэгдсэн ажлын байр,

↑ үр шим хүртсэн хүмүүсийн тоо г.м 10 Малчин айлийн ам бүл болох 75 хүн үр шим хүртэж байгаа

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ



Төслийн үр шимийг хүртсэн нэг болон нэлээн хэдэн хүн, байгууллагын өөрсдийнх нь ярьсан яриаг тухайн хүний харъялагдах аймаг, сум, байгууллага, БАХ-ийн нэр, овог нэртэй нь бүтэн оруулж бичнэ. Зураг оруулна.

Улаан харгана БАХ-ын малчин өндөр настан Б.Манат: Манай сумын Согоог багийн Улаан харгана БАХ-т Ногоон алт, Малын эрүүл мэнд төслийн хүрээнд хэрэгжиж байгаа хадлан хаших ажил амжилттай хэрэгжиж, өндөр ашиг шим хүртэх боломж олгосонд малчид бид баяртай байна. Тус талбайг малчид бид өөрийн хүч хөрөнгөөр 5

жил хашаалсан ч бүрэн дуусгаж чадаагүй тул сумын малчдын байгууллагад хүсэлт оруулсан нь дэмжигдсэнд маш их баярлаж байна. Тус жижиг төслийн ачаар 10 малчин өрхийн тэжээлийн нөөц нэмэгдэн, өвлийн бэлчээр хамгаалагдаж амьжиргаанд нь их хувь нэмэр болж байна. Согоог, Баянзүрх багийн их малтай зарим малчид намаржиж бидний өвөлжөөг сүйтгээд явдаг байлаа, Харин одоо хашаалсаны ачаар хэсэгхэн ч гэсэн газарт бэлчээрээ хамгаалж чадлаа. Тиймээс уг төслийг санаачлан хэрэгжүүлсэн сумын малчдын байгууллага, дэмжлэг үзүүсэн Ногоон алт, малын эрүүл мэнд төслийн хамт олонд баярлаж талархсанаа илэрхийлье.. Бусад малчид хэсэг, бүлгүүд үлгэр жишээ авч хамтарч ажиллахыг хүсье.



